



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Боловсролын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Боловсролын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлт бүртгэлийг зохион байгуулах, боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах зорилгоор дор дурдсан байгууллага, албан тушаалтанд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ДААЛГАХ нь:

Нэг. Дүүргийн Засаг дарга нарт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй сургууль, цэцэрлэгийн барилгын ажлыг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих Ажлын хэсгийг байгуулж гүйцэтгэл, үр дүнг сар бүр тооцож ирүүлэх;

2. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулиудыг 3 ээлжээр хичээллэхгүй байхаар тооцож, хамран сургах тойргийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулан ирүүлэх;

3. Дүүргийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудыг 2 ээлжид шилжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, зайлшгүй 3 ээлжээр хичээллэх бүлгүүдийг ойр орчмын сургалтын зориулалтаар ашиглах боломжтой байруудад шилжүүлэн суралцуулах судалгааг нарийвчлан гаргаж ирүүлэх;

4. Элсэлт зохион байгуулах үед үүсдэг аливаа хууль бус үйлдэл /хуурамч бичиг баримт бүрдүүлэх, албан тушаалтан хуурамч тодорхойлолт гаргах гэх мэт/-ийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан тохиолдолд холбогдох арга хэмжээ авч ажиллах;

5. Өмчийн хэлбэр үл харгалзан сургууль, цэцэрлэгийн дотоод, гадаад орчны аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, болзошгүй эрсдэлийг бууруулан ажиллах.

Хоёр. Нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт:

1. Дүүргээс ирсэн саналыг үндэслэн хамран сургах тойргийг шинэчлэн тогтоож, ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийг 5 дугаар сард багтаан иргэд, олон нийтэд хүндрэлгүй явуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

2.Цэцэрлэг, зарим ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хэрэгжүүлэх;

3.Сурагчдын зуны амралтын хугацаанд тэднийг аюул ослоос урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих талаар зөвлөмж гарган эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлан таниулах;

4.Нийслэлийн Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, 15 хоног тутам тайлан мэдээ гарган ажиллах;

5.Анги дэвших, төгсөх болон элсэлтийн ерөнхий шалгалтыг өндөр түвшинд зохион байгуулах.

Гурав. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төгсөлтийн үйл ажиллагааг боловсролын баримт бичиг гардуулах, суралцагч өөрийн сурсан эрдэм, авьяасаа тайлагнах арга хэмжээ болгон тэмдэглэн өнгөрүүлэх;

2.Суралцагчдаас хуульд заагаагүй аливаа төлбөр, хураамж, хандив авах, суралцагчдыг хамруулан амралт, зугаалгын арга хэмжээ зохион байгуулахыг хориглох;

3.Нэгдүгээр ангид элсэгчдийн судалгааг нарийвчлан гаргаж, гуравдугаар ээлжгүй байхаар зохицуулалт хийж, бүртгэлийг иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй явуулах;


4.Хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг нарийвчлан гаргаж тэгш хамруулан сургах ажлыг зохион байгуулах;

5.Сургуулийн дотоод, гадаад орчны аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах;

6.Сургуулийн өвөлжилтийн бэлтгэл ажил болон урсгал засварыг эрт төлөвлөж, хичээлийн жил эхлэхээс өмнө бүрэн дуусгах.

Дөрөв.Энэ албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН